

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
БАТ-ОЧИРЫН ГАНЗОРИГИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**



7800000

Миний бие Монгол улсын иргэн Бат-Очирын Ганзориг нь Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд Төмөрбулаг сумаас бие даан нэр дэвшиж байна. Монгол Улсын иргэд төлөөлөгчөөрөө дамжуулан төрийн эрхийг барих боломжтой ардчилсан Үндсэн хуультай болоод 28 жилийн нүүрийг үзэж, нутгийн өөрөө удирдах ёс тодорхой хэмжээнд хэрэгжиж, орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн. Хэдий тийм боловч төрийн бодлого шийдвэр иргэдийн амьдралд бодит нөлөө үзүүлэхгүй, төрийн үйлчилгээ иргэн бүрт тэгш, хүртээмжтэй хүрч чадахгүй, төрөөс зайлшгүй зохицуулалт, дэмжлэг шаардлагатай байгаа нийгмийн тулгамдсан асуудлууд шийдэгдэхгүй байсаар байна. Тиймээс би Хөвсгөл аймаг, Төмөрбулаг сумыг тогтвортой хөгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан төрөөс хэрэгжүүлж болох бодлогыг орон нутгийн түвшинд тодорхойлж, шийдвэрлэх зорилго бүхий мөрийн хөтөлбөрөө Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын иргэддээ танилцуулж байна.

Нэг. Хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

- 1.1. Мал сүргийг зохистой харьцаагаар өсгөх бодлогыг дэмжиж, малын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, отрын бүс нутгийг шинэчлэн тогтооно.
- 1.2. Малын түүхий эд, сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх хөдөө аж ахуйн бирж байгуулах талаар санаачлага гаргаж, төр, иргэн, аж ахуй нэгжийн хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажиллана.
- 1.3. Сумын худаг, усны цэгийн тоог нэмэгдүүлж бэлчээр ашиглалтыг сайжруулах, хамгаалах шаардлагатай булаг шанд, усны эхийн судалгааг гаргаж, хашиж хамгаалах талаар нутгийн иргэд, олон нийттэй хамтарч ажиллана.
- 1.4. Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангахад төр, олон нийтийн оролцоо, нөхөрлөлийн уялдаа холбоог хангаж хамтран ажиллана.
- 1.5. Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж хамгаалах бодлогыг ямагт эрхэмлэж, хүний нөлөөллөөс үүдэлтэй байгаль орчныг бохирдуулах үйлдлийг бууруулах, таслан зогсоох талаарх санал санаачлага, бодлого, хөтөлбөрийг дэмжинэ.

67171
РЦА0038

- 1.6. Сумын төвийн нэгдсэн халаалтад холбогдох айл өрх, хувийн хэвшлийн тоог нэмэгдүүлэх бодлого, үйл ажиллагааг дэмжиж, иргэд, хувийн хэвшилтэй хамтарч ажиллана.
- 1.7. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас эвдэрч сүйдсэн зам, даваа, гүүрийг засч сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллана.
- 1.8. Аймгийн аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэх, аяллын маршрутыг олшруулах, гадаадын болон дотоодын жуулчдыг нэмэгдүүлэх, аймгийн иргэд, аж ахуй нэгж аялал жуулчлалаас орлого олох боломжийг нэмэгдүүлэх талаарх санал санаачлагыг дэмжинэ.

Хоёр. Эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хамгаалалын чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

- 2.1. Нийгмийн эрүүл мэндийг дархлаажуулах, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхитэй, эрүүл хэв маягаар амьдрах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ.
- 2.2. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, нас баралт, өвчлөлтийн шалтгааныг багасгах талаарх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх талаарх ажлыг эрчимжүүлэхэд санаачлага гаргаж ажиллана.
- 2.3. Сумдад нарийн мэргэжлийн эмч /эмэгтэйчүүд, хүүхэд/ нар тогтвор суурьшилтай ажиллах талаар бодлогыг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.
- 2.4. Сумын иргэдийг жил бүр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, соёлын төвийн техник хэрэгслийг нэмэгдүүлэх, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвд тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд шаардлагатай чийрэгжүүлэлтийн болон бусад тоног төхөөрөмжөөр хангах талаар арга хэмжээ авч ажиллана.
- 2.5. Сургуулийн дотуур байрны хүүхдүүдийн хатуу, зөөлөн эдлэлийг шинэчилж, амьдрах орчныг сайржуулах, СӨБ-ын хүүхдүүдийн тоглоомын талбайг тохижуулах, номын сангийн номын тоог нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.

Гурав. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, амжиргааг сайжруулах чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлнэ.

- 3.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, хөдөө аж ахуйн сангууд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг иргэдийн хөдөлмөр эрхлэлт, амжиргааг дэмжих

4193
6070605

зорилго бүхий төрийн санхүүжилт бүхий санд иргэн бүр шударгаар өрсөлдөх боломжийг хангахад анхаарч ажиллана.

- 3.2. Ажил олгогч иргэн, аж ахуй нэгжүүдийг төсөл, хөтөлбөр, зээл, тусламжид хамруулах бодлогоор дэмжинэ.
- 3.3. Малын түүхий эд, бүтээгдэхүүн, гар урлалын бүтээгдэхүүн, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдэвлэгч, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, үйлчилгээний бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 3.4. Иргэдийн хөдөлмөр эрхлэлт, амжиргааг дээшлүүлэх талаарх төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллана.

Дөрөв. Төрийн үйлчилгээг чанаржуулах, удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлнэ.

- 4.1. Төрөөс гаргасан бодлого шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, мэдээ, мэдээллийг цаг алдалгүй иргэд, аж ахуй нэгжид хүргэх, мэдээлэлд ойр байх боломжийг бүрдүүлнэ.
- 4.2. Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд хурдан шуурхай шийдвэрлэх, төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх талаар анхаарч ажиллана.
- 4.3. Төрийн албан хаагчдын чадвар, чадамжийг сайжруулах, төрийн албанд ороход иргэн бүр шудрага өрсөлдөх боломжийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж, арга хэмжээ авна.
- 4.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа талаар тогтмол хяналт тавьж, үр нөлөөг сайжруулна.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН

 Б.ГАНЗОРИГ

ж

